

### ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Компани 2017 онд 11 төсөвт байгууллага, 128 аж ахуйн нэгж, 1134 айл өрх, нийт 1273 хэрэглэгчтэй ус, дулааны эрчим хүчээр хангаж, бохир ус татан зайлуулах гэрээ байгуулан ажилласан.

#### 1. Дулааны эрчим хүч

Тайлант онд 40.9 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэхээс 39.8 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн 97.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь дулаан дамжуулах шугам шинэчлэлийн ажлаас шалтгаалан төлөвлөгөөт үйлдвэрлэл 25 хоногоор тасарснаас /09.15-10.10/, мөн 11 дүгээр сараас үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчийг тоолуураар тооцож эхэлсэн зэргээс үйлдвэрлэлийн төлөвлөгөө 2.4 мян.Гкал-аар тасарсан.

Зуны улиралд 1 зуух галлан орон сууцны хэрэглэгчдийг хэрэгцээний халуун усаар ханган ажилласан. 335.2 тн нүүрс шатааж 1.3 мян.Гкал дулааны эрчим хүчийг үйлдвэрлэсэн.

#### Шугам шинэчлэлийн ажлаас:

Сар	төлөвлөгөө	гүйцэтгэл	гкал зөрүү
IX	1,304.2	0	-1,304.2
X	4,031.0	3,785.0	-246
	5,335.2	3,785.0	-1,550.2

#### ДЭХ-ний тоолуураас:

Сар	төлөвлөгөө	гүйцэтгэл	гкал зөрүү
XI	5,631.6	5,286.2	-345.4
XII	6,550.4	5,971.4	-579.0
	12,182.0	11,257.6	-924.4

Сүлжээний нэмэлт усны зарцуулалт төлөвлөгөөнөөс 13.0 мян.м<sup>3</sup>-ээр буурч 25.9 мян.м<sup>3</sup> гарсан байна. Усны алдагдалтай холбоотой дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан, дулаан дамжуулах сүлжээ, түгээх сүлжээнд гарсан гэмтлийг шуурхай устгаж, түгээх шугамын шинэчлэлийн ажлыг үе шаттай хийж байгаа зэргээс шалтгаалан нэмэлт усны алдагдал багассан. Мөн Сумын хуучин тосгоны 2 давхар байрууд нь хэрэгцээний халуун усны шугамгүй учир хэрэглэгчид сүлжээний усыг зүй бусаар ашиглаж нэмэлт усны зарцуулалтыг ихэсгэдэг байдалд хяналт тавьж хэрэглэгчдээр эргэлт, ухуулга сурталчилгаа хийх, системд тавьсан крантыг авч заглушка тавих зэрэг ажил зохион байгуулан ажилласан. Сүлжээний нэмэлт усны цагийн зарцуулалт 3-5м<sup>3</sup>/ц болон буурсан. Технологийн давс 31.1 тонныг хэрэглэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 22.2 тонн буюу 29 хувиар буурсан байна.

2. Ус хангамж, ариутгал татуурга

455.9 мян.м<sup>3</sup> ус олборлохоос 448.3 мян.м<sup>3</sup> ус олборлон 98.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь усны тоолууржилтаас шалтгаалан зохистой хэрэглээ нэмэгдэж байгааг харуулж байна.

Одоогийн байдлаар төсвийн байгууллагын 63 хувь, бусад аж ахуй нэгж 61.8 хувь, айл өрхийн 71.9 хувь нь цэвэр усны тоолууржилтанд хамрагдсан байна. Энэ онд 48 айл өрх, 4 аж ахуй нэгжид нийт 105 ширхэг тоолуур шинээр суурилуулсан.

352.1 мян.м<sup>3</sup> бохир ус татан зайлуулахаас гүйцэтгэлээр 316.1 мян.м<sup>3</sup> бохир усыг татан зайлуулсан байна.

**Үндсэн үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдийг мөн үетэй харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:**

№	Нэр	Хэмжих нэгж	2016	2017		зөрүү	
			гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	өмнөх оноос	төлөвлөгөөнөөс
1	Үйлдвэрлэсэн ДЭХ	мян.Гкал	41.3	40.9	39.8	-1.5	-1.1
2	Дотоод хэрэглээ	мян.Гкал	3.2	3.2	2.9	-0.3	-0.3
3	Түгээсэн ДЭХ	мян.Гкал	37.9	37.7	36.9	-1	-0.8
4	Нэмэлт ус	мян,тн	28.3	39.0	25.2	-3.2	-13.8
5	Нүүрс	мян,тн	13.5	13.8	13.2	-0.3	-0.6
6	Давс	мян,тн	22.2	31.2	22.2	-	-9.0
7	Цэвэр ус	мян,тн	437.0	455.9	448.3	11.3	-7.6
8	ЦЭХ-ний хэрэглээ	мян,кВт	2 097.9	2 085.8	2 117.5	19.6	31.7

2017 онд 2.085,8 мян.кВт ЦЭХ хэрэглэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,117.5 мян.кВт хэрэглэсэн байна. Энэ нь төлөвлөгөөнд тусгагдаагүйгээр зуны улиралд зуух галлан орон сууцны хэрэглэгчдэд хэрэгцээний халуун ус түгээн ажилласан, мөн шинээр хэрэглэгч нэмж холбогдсоны улмаас зуухны хүчин чадлыг төлөвлөснөөс нэмэгдүүлж галласан зэргээс цахилгаан эрчим хүчний хэрэглээ өндөр гарсан. Үүнтэй холбоотойгоор цахилгааны хэрэглээ төлөвлөгөөнөөс хэтэрсэн асуудлыг Эрчим хүчний зохицуулах хороонд хандан зохицуулалт хийлгэн, 8 дугаар сарын 01-ээс 12 дугаар сарыг дуустал цахилгаан эрчим хүчний төлбөрийг 35 хувиар хөнгөлөх шийдвэр гарч, 40.8 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.

Хэрэглэгчдээс нийт 1309 дуудлага хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан. Ажил үйлчилгээний орлого 2,218.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Дуудлагыг төрлөөр нь ангилвал:

- Халаалт – 171
- Хэрэгцээний халуун ус – 154
- Цэвэр ус – 460
- Бохир ус – 229
- Тоолуур – 104
- Бусад - 191

## ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЫН ТАЛААР:

2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах 22 багц ажилтай төлөвлөгөөг батлуулан 100% биелэлтийг ханган ажилласан.

## ИХ ЗАСВАР, ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Компанийн ТУЗ-ийн 2017.01.26-ны өдрийн 01 тоот тогтоолоор 2017 оны их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар 177.7 сая төгрөгийн 13 төрлийн ажил хийгдэхээр төлөвлөгөөг батлуулсан байна.

2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 2017.05.15-ны өдөр нягтын шахалт хийх үед К2-К9 дүгээр худгийн хоорондох дулаан түгээх гол шугамд гэмтэл гарч, шугам хоолойг солих зайлшгүй шаардлагатай болсон. Уг шинэчлэлийн ажилд 13.8 сая төгрөг шаардагдаж байсан тул К66-К68 дугаар худгийн хоорондох шугамын нэвтрүүлэх чадварын нэмэгдүүлэх, тосон таслуур суурилуулах, үнс баригч худалдан авах 3 ажлыг хойшлуулж шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг санхүүжүүлэн К2-К9 худгийн шугам шинэчлэл, мөн мэргэжлийн хяналтын шаардлагын дагуу үйлдвэрийн бага эмчийн өрөөний тоног төхөөрөмжийг 3.3 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөгөөнд тодотгол хийн шийдвэрлүүлсэн.


2017 оны их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 177.7 сая төгрөгөөр 12 төрлийн ажил хийхээр төлөвлөж, 171.5 сая төгрөг зарцуулан төлөвлөгөөт ажлуудыг 100 хувь хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Их засвараар 5 ажил хийгдэж, 116.1 сая төгрөгийг,
- ТЗБАХ-ээр 3 ажил хийгдэж, 13.6 сая төгрөгийг,
- Хөрөнгө оруулалтын 4 төрлийн ажилд 41.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## УРСГАЛ ЗАСВАР:

Зуух, туслах тоноглол, шугам сүлжээний урсгал засварт 37 нэр төрлийн ажил хийхээр төлөвлөж, 61.7 сая төгрөгт зарцуулан 100 хувь хийж гүйцэтгэсэн.

ИЗ, ТЗБАХ, ХО-д зарцуулсан хөрөнгийг графикаар харуулвал:



## Компанийн 2017 оны ИЗ, ТЗБАХ, ХО-ын гүйцэтгэл


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмж их нэгж	Тоо, хэмжэ э	Шаардагд ах хөрөнгө /мян.төг/	зарцуулса н хөрөнгө /мян.төг/	хөрөнгий н хувь	гүйцэтгэли йн хувь
<b>1. Их засвар</b>							
1	Дулааны станцын барилгын дээврийн засварын ажил хийх	м2	510	25 318	25 318	100%	100%
2	К2-р зуухны халаах гадаргуу, чиглүүлэгч бетон болон ул ширэмний засвар	ком	1	29 138	28 312	97%	100%
3	15-р байрны салбар шугам солих	м	750	33 249	31 830	96%	100%
4	Зөөврийн 2-р худгийн засвар шинэчлэл	ком	1	19 332	19 332	100%	100%
5	К2-оос К9 хүртэлх хэрэгцээний халуун хүйтэн ус, дулааны эрчим хүч түгээх салбар шугам шинэчлэх	м	300	13 888	11 323	82%	100%
	<b>ДҮН</b>			<b>120 925,4</b>	<b>116 115,1</b>	<b>96%</b>	<b>100%</b>
<b>2. ТЗБАХ</b>							
1	Үнсний 3-р конвейерийн засвар шинэчлэлтийн ажил	ком	1	4 045	3 347,9	83%	100%
2	Бохир усны гаралтанд тоолуур тавих	ком	2	3 528	5 218,5	148%	100%
3	ХХУ-ны бойлерт автомат хаалт, тоолуур тавих	ком	1	7 375	5 046,6	68%	100%
	<b>ДҮН</b>			<b>14 948,0</b>	<b>13 613,0</b>	<b>91%</b>	<b>100%</b>
<b>3. Хөрөнгө оруулалтаар</b>							
1	Бохир усны насос /СД 160/45/	ком	1	9 000	9 000,0	100%	100%
2	Давтамж хувьсгуур /250 кВт/	ком	1	20 000	20 000,0	100%	100%
3	Цэвэр усны насос /Д 200/70/	ком	1	9 500	9 500,0	100%	100%
4	Үйлдвэрийн бага эмчийн өрөөний эд зүйлс, тоног төхөөрөмж			3 332	3 273,5	98%	100%
	<b>ДҮН</b>			<b>41 831,6</b>	<b>41 773,5</b>	<b>100%</b>	<b>100%</b>
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>177 705,0</b>	<b>171 501,6</b>	<b>97%</b>	<b>100%</b>

**ТЕХНИКИЙН ДЭВШЛИЙН ТАЛААР:**

1. Дулааны станцаас дулаан хуваарилах төв хүртэлх ус, дулаан дамжуулах төв шугамын шинэчлэлийн ажлыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр “Бурхант хясаат” ХХК хийж гүйцэтгэн бүрэн ашиглалтанд оруулсан.



2. Сумын гэр хорооллын иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усаар тасралтгүй 24 цагаар хангах цахим худгийг өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтанд оруулсан.




"Дулаан шарын гол" ТӨХК-ийн ус түгээх 2-р худгийн 2017 оны борлуулалт

/2017-07-21-ээс 2017-12-31/



д/д	х.н	2017 он						НИЙТ
		7	8	9	10	11	12	
Карт	төг	105000	25000	5000	30000	30000	25000	220000
Ус	тн	46,3	27,8	1,0	22,0	43,9	42,8	183,71
	төг	92500	55500	2000	44000	87750	85670	367420
<b>НИЙТ ОРЛОГО</b>		<b>197500</b>	<b>80500</b>	<b>7000</b>	<b>74000</b>	<b>117750</b>	<b>110670</b>	<b>587420</b>
Усны зарцуулалт	тн	7,8	9,7	3,1	16,2	29,7	43,9	110,4
	төг	15576	19466	6142	32374	59458	87812	220828
Усны үлдэгдэл	тн	38,5	56,5	54,4	60,2	74,4	73,3	
	төг	76924	112958	108816	120442	148734	146592	

Ус түгээх 1-ээс 6-р худгуудын 2017 оны усны борлуулалт



д/д	Худаг	2017 он						НИЙТ
		7	8	9	10	11	12	
1	2 худаг	7,8	9,7	3,1	16,2	29,7	43,9	110,4
2	1,6 худаг	140	95	80	110	110	120	655,0
3	4,5 худаг	75	60	45	55	70	75	380,0
4	3 худаг	70	55	40	50	55	70	340,0
<b>НИЙТ</b>		<b>292,8</b>	<b>219,7</b>	<b>168,1</b>	<b>231,2</b>	<b>264,7</b>	<b>308,9</b>	<b>1485,4</b>



3. Сүлжээний усны насосанд давтамж хувьсгуур суурилуулан хувьсах горимоор ажиллуулдаг болсон.





4. Дулаан дамжуулах шугам шинэчлэлийн ажлын хүрээнд дулааны станцад Дани улсын Камstrup фирмийн МУЛЬТИКАЛЬ 602 загварын дулааны тоолуурыг шинээр суурилуулснаар сүлжээний усны зарцуулалт, үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчний тоо хэмжээг бодитоор хэмжих, хянах боломж бүрдсэн.





5.  $0.7-16.0 \text{ кгх/см}^2$  даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл авч өөрсдийн ажиллах хүчээр К2 дугаар зуухны халах гадаргууг шинэчлэн солих ажлыг хийж гүйцэтгэсэн.

**К2-Р ЗУУХНЫ ЗАСВАРЫН ЗУРАГ**




Экран хоолойд гагнуур хийж байгаа.






6. Зуны улиралд зуух галлаж, хэрэглэгчдийг хэрэгцээний халуун усаар ханган ажилласан. Энэ үед ЦН400/105 маркын сүлжээний насосыг ажиллуулахгүй, хүчин чадлыг багасган Д320/50 маркын хуучин насосыг угсарч, монтажлан ажиллуулснаар цахилгаан эрчим хүчний хэрэглээг тодорхой хэмжээгээр бууруулан ажилласан.



7. Ус хангамжийн өргөх станцад одоогийн хэрэглээнд тохирсон Д200/90 насос шинээр угсарч, давтамж хувьсгуур суурилуулан, хувьсах горимоор ажиллуулдаг болсноор сард 13.6 мян.кВт цахилгаан эрчим хүчийг тогтмол хэмнэх боломж бүрдсэн байна.

Усан сан дээр шинээр Д200/90 насос угсрав.




- Гэмтэл саатал, ослоос урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажилласнаар технологийн зөрчилгүй ажилласан байна.
- Компанийн ажилчдын дунд аюулыг мэдээллэх хуудсыг ашиглан мэдээлэл өгч ажиллах журмыг шинэчлэн гаргаж батлуулан аюулыг мэдээллэх хуудсыг хэрэгжүүлэн нийт 78 аюулыг мэдээллэж, устгах арга хэмжээг авч ажилласан.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг гүйцэтгэх захирлын 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/26 тоот тушаалаар ХАБЭААжилтан, ҮЭХ-н дарга, Дотоод хяналтын ажилтан, ҮЭХ-н тэргүүлэгч, Ахлах лаборант нарын 5 бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталж ажилласан.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийн 18.1.2 дахь заалтын дагуу нийт ажилтнуудыг Практикал даатгалтай гэрээ байгуулан даатгалд хамруулсан.
- Аваари ослоос урьдчилан сэргийлж ажлын байрны I, II шатны үзлэгийг тогтмол хийж, III шатны үзлэгийг улирал бүр удирдлага болон ҮЭХ, ХАБЭА-н зөвлөлтэй хамтран зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. Үзлэгээр нийт 232 зөрчил илрүүлэн устгуулах арга хэмжээг авч ажилласан.


Алба хэсгүүдийн тоног төхөөрөмжүүдэд байрлуулах анхааруулах, сануулах, хориглох, зөвшөөрөх аюулгүй ажиллагааны плакатыг өөрсдийн нөөц бололцоогоор хийж ажлын байруудад байрлуулсан.





Зуны их болон урсгал засварын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж аюулгүй ажиллагааг хангуулж хамгаалах тууз болон анхааруулах, хориглох плакатуудыг хийж аюул осолгүй ажилласан.



Сумын Аврах гал унтраах 55 дугаар ангитай хамтран “Гал унтраах дасгал” сургуулилт хийхээр хөтөлбөр гаргаж 2017 оны 11 дүгээр сарын 27-30-ны өдөр зохион байгуулсан.



Дулааны станцын дээврийн засварын ажлыг хэсэгчлэн шинэчилж дээврээс ус гоожилтыг зогсоосон .



### БУСАД АЖЛЫН ТАЛААР

- 0.7-16.0 кгх/см<sup>2</sup> даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл шинээр авсан.
- Эрчим хүчний зохицуулах хороонд ДЭХ-ний тарифын саналыг хүргүүлж, 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 191 тоот тогтоолоор ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ үнэ тарифыг нэмэхээр батлагдаж 2017 оны 09 дүгээр сарын 15-аас мөрдөн ажилласан.
- Компанийн “Гамшгийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ”-г “ТАЙЖ СҮЛДЭТ ХИЙМОРЬ” ХХК-аар хийж гүйцэтгүүлэн, материалыг Дархан-Уул аймгийн Онцгой байдлын дарга, хурандаа Г.Батбаяраар хянаж батлуусан.
- Жил бүр зохион байгуулагддаг “Усны өдөр”-ийг угтан хэрэглэгчдэд гарын авлага тарааж, орон нутгийн телевизээр “Усны зохистой хэрэглээ”-ний талаар сурталчилгаа явуулж ажиллалаа.
- Шарын гол сумын нээлттэй хаалганы өдөрлөгөөр компанийн үйл ажиллагааг сурталчлан, найдвартай хэрэглэгчдийн дунд сугалаа явуулж 2 ААНБ, 4 айл өрхийг хөнгөлөлтийн эрхийн бичгээр урамшуулж амжилттай оролцсон.
- ЭХЯ-ны 95 жилийн ойн спортын арга хэмжээ, сумын болон Амгалан Дулааны станцаас зохион байгуулсан ижил төстэй байгууллагуудын аварга шалгаруулах спортын тэмцээнд удаа дараа амжилттай оролцсон.

2017-2020 онд хэрэгжүүлэхээр *"Инновацийг нэвтрүүлж, чанартай бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг найдвартай ханган, өртөг зардлыг бууруулах"* зорилго дэвшүүлэн 7 зорилт төлөвлөн ажиллаж байгаагаас энэ онд 4 ажил хийгдэж хэрэгжээд байна.

1. Шарын гол сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан дулаан болон ус хангамжийн эх үүсвэр, шугам хоолойг өргөтгөх, шинэчлэх
2. Орон сууцны байруудыг зуны улиралд хэрэгцээний халуун усаар хангах
3. Насосны станцуудыг хувьсах горимд шилжүүлэх
4. Диспетчерийн шуурхай удирдлагад хяналт, мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх
5. Дулааны сүлжээний гидравлик горимыг оновчтой тооцож, тохируулгыг чанартай гүйцэтгэх
6. Гэр хорооллын ус түгээх худгуудыг 24 цагийн ажиллагаатай ухаалаг системтэй ус түгээх байр болгох
7. Таван давхар орон сууцны хэрэгцээний халуун, хүйтэн усны босоо шугам шинэчлэх, хэрэглэгчдийн тоолуурыг төвлөрүүлэх

